**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2026/004/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2026.02.25<br>2026 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын<br>Дарга тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061861 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Азбаяр<br>Утас: 99061429 Цахим хаяг: Azbayarb@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА........ 12
4. АУДИТЫН ТАЙЛАН........ 16
4.1 Ерөнхий зүйл ........ 16
4.2 Материаллаг байдал ........ 16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт........ 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ........ 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement_bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/59

танай____________-ны № ____________-т

БАЯНХОНГОР АЙМГИЙН СТАНДАРТ
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Н.ШАГДАРСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Дээд шатны захирагчийн дэргэдэх дотоод аудитын алба нь татварын нэгдсэн систем дэх баримтжуулалттай холбоотой хоорондын тооцоонд хяналт

6426050178

хэрэгжүүлэхгүй байгаа нь тухайн асуудалтай холбоотой зөрчил арилахгүй, давтагдан гарах эрсдэлтэй байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **288,371,801.86** | **502,035,156.52** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | | 9,291,999.00 | 00.00 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | | 9,291,999.00 | 00.00 |
| **3121** | **Төгрөг** | | 9,291,999.00 | 00.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | | 9,291,999.00 | 00.00 |
| **33** | **АВЛАГА** | | 145,319,719.78 | 389,536,763.52 |
| **335** | **Бусад авлага** | | 145,319,719.78 | 389,536,763.52 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | 145,319,719.78 | 389,536,763.52 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | | 133,760,083.08 | 112,498,393.00 |
| **351** | **Түүхий эд материал** | | 61,567,019.19 | 48,776,360.49 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | 17,968,790.46 | 15,491,448.56 |
| 35130 | Эм боох материал | | 43,598,228.73 | 33,284,911.93 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | 1,024,685.00 | 1,115,012.50 |
| **354** | **Хангамжийн материал** | | 71,168,378.89 | 62,607,020.01 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 22,385,350.00 | 22,291,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 31,593,640.00 | 28,408,770.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | 1,480,000.00 | 00.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | 1,010,088.89 | 00.01 |
| 35450 | Барилгын засварын материал | | 12,874,000.00 | 9,345,000.00 |
| 35460 | Хүнсний материал | | 00.00 | 1,646,150.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 1,825,300.00 | 915,300.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **1,630,291,763.36** | **1,986,015,757.15** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | | 1,630,291,763.36 | 1,986,015,757.15 |
| **392** | **Биет хөрөнгө** | | 1,520,116,763.36 | 1,875,840,757.15 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 1,318,956,740.76 | 1,318,956,740.76 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (49,172,806.17) | (87,636,240.45) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 47,600,000.00 | 47,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | (13,090,000.11) | (16,660,000.14) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 428,662,069.00 | 673,884,369.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (230,894,886.45) | (101,602,005.59) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 48,933,633.30 | 44,215,399.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (33,269,653.89) | (9,075,839.97) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | | 3,500,000.00 | 3,500,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | | (1,108,333.08) | (1,341,666.36) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | 2,000,000.00 | 4,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | (2,000,000.00) | 00.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | 110,175,000.00 | 110,175,000.00 |
| 39301 | Программ хангамж | | 1,061,000.00 | 1,061,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | (1,061,000.00) | (1,061,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 110,175,000.00 | 110,175,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **1,918,663,565.22** | **2,488,050,913.67** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **2,112,926.89** | **194,863,521.02** |



003 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ

| | | | | |
|---|---|---|---|---|
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | | 2,112,926.89 | 194,863,521.02 |
| **413** | **Өглөг** | | 2,112,926.89 | 194,863,521.02 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | 2,112,926.89 | 21,560,952.00 |
| **4136** | **Бусад өглөг** | | 00.00 | 173,302,569.02 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 00.00 | 168,582,169.02 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | | 00.00 | 4,720,400.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **1,916,550,638.33** | **2,293,187,392.65** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 1,916,550,638.33 | 2,293,187,392.65 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 96,568,996.01 | 96,568,996.01 |
| 51101 | Өмч: - төрийн | | 96,568,996.01 | 96,568,996.01 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | 1,774,542,943.23 | 2,151,602,837.55 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 1,774,542,943.23 | 1,635,045,067.20 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 00.00 | 516,557,770.35 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 45,438,699.09 | 45,015,559.09 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **1,918,663,565.22** | **2,488,050,913.67** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | | **2,595,599,515.30** | **1,728,495,246.90** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **1,597,426,804.80** | **1,296,443,847.40** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 1,597,426,804.80 | 1,296,443,847.40 |
| 120002 | Хүүгийн орлого | | 1,239,335,568.80 | 348,462,937.40 |
| 120003 | Торгуулийн орлого | | 1,023,100.00 | 1,139,570.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 357,068,136.00 | 946,841,340.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 348,268,136.00 | 946,841,340.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 8,800,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **998,172,710.50** | **432,051,399.50** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | 488,509,600.00 | 371,942,761.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 488,509,600.00 | 371,942,761.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 509,663,110.50 | 60,108,638.50 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 00.00 | 8,195,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 00.00 | 2,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 26,432,310.50 | 19,232,638.50 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 473,630,800.00 | 30,681,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | 9,600,000.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | | **1,139,322,505.29** | **1,211,937,476.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **1,139,322,505.29** | **1,211,937,476.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 924,862,638.29 | 1,177,129,061.92 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 499,116,904.00 | 635,825,948.70 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | | 304,578,020.00 | 368,541,297.47 |
| 210102 | Нэмэгдэл | | 136,957,984.00 | 180,780,044.23 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 15,536,500.00 | 50,296,557.00 |
| 210104 | Урамшуулал | | 42,044,400.00 | 36,208,050.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 60,716,413.72 | 77,043,595.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 39,340,834.05 | 49,234,484.81 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 5,005,649.19 | 6,387,877.98 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 4,652,560.24 | 7,677,195.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 2,343,471.45 | 3,004,164.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 9,373,898.79 | 10,739,872.57 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 109,709,163.08 | 118,422,416.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 10,861,065.08 | 17,160,876.90 |
| 210302 | Түлш, халаалт | | 85,898,320.00 | 95,114,784.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 5,801,378.00 | 6,146,756.00 |
| 210304 | Байрны түрээс | | 7,148,400.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 24,564,410.94 | 35,342,198.78 |
| 210401 | Бичиг хэрэг | | 6,549,940.00 | 7,875,220.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 3,143,862.01 | 5,101,421.88 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 3,044,940.00 | 3,966,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | 128,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 1,200,000.00 | 900,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 4,664,570.00 | 17,499,356.90 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 5,833,098.93 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | 39,299,308.94 | 60,791,245.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 35,948,818.94 | 56,204,668.80 |
| 210502 | Хоол, хүнс | | 3,350,490.00 | 4,586,577.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 36,253,400.00 | 62,205,115.00 |
| 210604 | Урсгал засвар | | 36,253,400.00 | 62,205,115.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 46,278,623.00 | 36,220,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 46,278,623.00 | 36,220,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 40,327,070.00 | 45,517,475.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 32,100,000.00 | 42,813,350.50 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 619,500.00 | 540,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 55,960.00 | 99,582.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | 00.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 6,238,000.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 255,960.00 | 918,300.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 1,057,650.00 | 1,113,242.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 68,597,344.61 | 105,760,266.61 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 900,000.00 | 1,623,050.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 66,000.00 | 10,972,273.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 67,631,344.61 | 93,164,943.61 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 214,459,867.00 | 34,808,414.63 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 116,155,116.00 | 9,349,617.11 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 34,471,600.00 | 6,849,617.11 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 20,283,516.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 61,400,000.00 | 2,500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 98,304,751.00 | 24,848,797.52 |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | | 98,304,751.00 | 24,848,797.52 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 00.00 | 610,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 00.00 | 610,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | | **1,456,277,010.01** | **516,557,770.35** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | | **1,456,277,010.01** | **516,557,770.35** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | | **264,752,671.50** | **1,378,892,739.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **130,404,534.00** | **946,841,340.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 130,404,534.00 | 946,841,340.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | 130,404,534.00 | 946,841,340.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 130,404,534.00 | 946,841,340.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **134,348,137.50** | **432,051,399.50** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | 128,289,900.00 | 371,942,761.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 128,289,900.00 | 371,942,761.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 6,058,237.50 | 60,108,638.50 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 00.00 | 8,195,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 00.00 | 2,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2,894,737.50 | 19,232,638.50 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 3,163,500.00 | 30,681,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | | **140,456,401.00** | **1,384,814,738.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **140,456,401.00** | **1,384,814,738.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **140,206,401.00** | **961,372,984.87** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 85,618,259.00 | 630,609,703.87 |
| 210101 | Үндсэн цалин | | 57,269,174.00 | 335,410,829.05 |
| 210102 | Нэмэгдэл | | 22,122,585.00 | 187,451,348.97 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 3,591,000.00 | 59,562,726.00 |
| 210104 | Урамшуулал | | 2,635,500.00 | 48,184,799.85 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 7,392,291.00 | 77,174,280.73 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 5,026,754.48 | 53,143,818.59 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 591,382.88 | 5,985,819.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 295,691.44 | 3,179,978.97 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 295,691.44 | 2,952,372.91 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 1,182,770.76 | 11,912,291.26 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 32,659,651.00 | 116,992,866.77 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 3,383,638.00 | 15,575,654.77 |
| 210302 | Түлш, халаалт | | 26,822,331.00 | 96,883,584.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 2,453,682.00 | 4,533,628.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 1,343,300.00 | 5,016,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 225,500.00 | 725,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 75,900.00 | 981,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 574,100.00 | 2,089,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 100,000.00 | 800,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 367,800.00 | 420,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | | 2,114,900.00 | 20,094,991.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | 1,472,070.00 | 16,542,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 562,830.00 | 1,869,391.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 80,000.00 | 1,682,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 00.00 | 20,195,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 00.00 | 1,617,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 00.00 | 18,578,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 3,000,000.00 | 14,768,781.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 3,000,000.00 | 14,768,781.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 7,650,000.00 | 47,481,911.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 7,650,000.00 | 46,980,379.50 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 00.00 | 99,582.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | 00.00 | 33,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 00.00 | 75,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | 00.00 | 293,950.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 428,000.00 | 29,037,750.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 280,000.00 | 18,184,377.02 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 148,000.00 | 10,853,372.98 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **250,000.00** | **423,441,753.63** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 250,000.00 | 9,349,617.11 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 00.00 | 6,849,617.11 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 250,000.00 | 2,500,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 00.00 | 24,848,797.52 |
| 213304 | Хөрөнгийн | | 00.00 | 24,848,797.52 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 00.00 | 389,243,339.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 00.00 | 389,243,339.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | | **124,296,270.50** | **(5,921,999.00)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | | **00.00** | **3,370,000.00** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **00.00** | **3,370,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | 00.00 | 3,370,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 00.00 | 3,370,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | | **00.00** | **(3,370,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | 124,296,270.50 | (9,291,999.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 1,291,999.00 | 9,291,999.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 9,291,999.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 96,568,996.01 | 54,112,803.69 | 52,859,073.74 | 203,540,873.44 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **96,568,996.01** | **54,112,803.69** | **52,859,073.74** | 203,540,873.44 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 78,084,708.64 | 78,084,708.64 |
| **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **96,568,996.01** | **45,438,699.09** | **1,774,542,943.23** | 1,916,550,638.33 |
| **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **96,568,996.01** | **45,438,699.09** | **1,774,542,943.23** | 1,916,550,638.33 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | (139,497,876.03) | (139,497,876.03) |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **96,568,996.01** | **45,438,699.09** | **1,635,045,067.20** | 1,777,052,762.30 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | (423,140.00) | 00.00 | -423,140.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 516,557,770.35 | 516,557,770.35 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **96,568,996.01** | **45,015,559.09** | **2,151,602,837.55** | 2,293,187,392.65 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| **Эдийн засгийн ангилал** | **Төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 936,942,800.00 | 912,093,963.48 | 24,848,836.52 | 97.3 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 371,942,800.00 | 347,093,963.48 | 24,848,836.52 | 93.3 |
| Улсын төсвөөс санхүүжих | 371,942,800.00 | 347,093,963.48 | 24,848,836.52 | 93.3 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 565,000,000.00 | 565,000,000.00 | - | 100.0 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 565,000,000.00 | 565,000,000.00 | - | 100.0 |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 936,942,800.00 | 912,093,963.48 | 24,848,836.52 | 97.3 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 936,942,800.00 | 912,093,963.48 | 24,848,836.52 | 97.3 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 930,093,100.00 | 905,244,346.37 | 24,848,753.63 | 97.3 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 611,625,400.00 | 611,377,065.37 | 248,334.63 | 100.0 |
| Үндсэн цалин | 335,411,300.00 | 335,410,829.05 | 470.95 | 100.0 |
| Нэмэгдэл | 168,373,500.00 | 168,218,710.47 | 154,789.53 | 99.9 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 59,655,800.00 | 59,562,726.00 | 93,074.00 | |
| Урамшуулал | 48,184,800.00 | 48,184,799.85 | 0.15 | 100.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 77,406,100.00 | 77,174,280.73 | 231,819.27 | 99.7 |
| Тэтгэврийн даатгал | 53,413,100.00 | 53,143,818.59 | 269,281.41 | 99.5 |
| Тэтгэмжийн даатгал | 6,041,100.00 | 5,985,819.00 | 55,281.00 | 99.1 |
| ҮОМШӨ-ний даатгал | 3,026,700.00 | 3,179,978.97 | - 153,278.97 | 105.1 |
| Ажилгүйдлийн даатгал | 2,985,100.00 | 2,952,372.91 | 32,727.09 | 98.9 |
| Эрүүл мэндийн даатгал | 11,940,100.00 | 11,912,291.26 | 27,808.74 | 99.8 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 117,563,400.00 | 116,992,866.77 | 570,533.23 | 99.5 |
| Гэрэл, цахилгаан | 15,994,500.00 | 15,575,654.77 | 418,845.23 | 97.4 |
| Түлш, халаалт | 96,885,200.00 | 96,883,584.00 | 1,616.00 | 100.0 |
| Цэвэр, бохир ус | 4,683,700.00 | 4,533,628.00 | 150,072.00 | 96.8 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 11,066,200.00 | 5,016,800.00 | 6,049,400.00 | 45.3 |
| Бичиг хэрэг | 1,995,000.00 | 725,600.00 | 1,269,400.00 | 36.4 |
| Тээвэр, шатахуун | 3,981,000.00 | 981,000.00 | 3,000,000.00 | 24.6 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,597,400.00 | 2,089,800.00 | 507,600.00 | 80.5 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,196,800.00 | 800,000.00 | 396,800.00 | 66.8 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,296,000.00 | 420,400.00 | 875,600.00 | 32.4 |
| **Нормативт зардал** | 31,802,700.00 | 20,094,991.00 | 11,707,709.00 | 63.2 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 24,932,800.00 | 16,542,800.00 | 8,390,000.00 | 66.3 |
| Хоол, хүнс | 2,880,200.00 | 1,869,391.00 | 1,010,809.00 | 64.9 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,989,700.00 | 1,682,800.00 | 2,306,900.00 | 42.2 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 22,055,900.00 | 20,195,900.00 | 1,860,000.00 | 91.6 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,477,000.00 | 1,617,000.00 | 1,860,000.00 | 46.5 |
| Урсгал засвар | 18,578,900.00 | 18,578,900.00 | 0.00 | 100.0 |
| **Томилолт, зочны зардал** | 16,878,800.00 | 14,768,781.00 | 2,110,019.00 | 87.5 |
| Дотоод албан томилолт | 16,878,800.00 | 14,768,781.00 | 2,110,019.00 | 87.5 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 41,357,800.00 | 39,286,911.50 | 2,070,888.50 | 95.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,830,000.00 | 38,785,379.50 | 44,620.50 | 99.9 |
| Даатгалын үйлчилгээ | 617,100.00 | 99,582.00 | 517,518.00 | 16.1 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 55,700.00 | 0.00 | 55,700.00 | 0.0 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 34,300.00 | 33,000.00 | 1,300.00 | 96.2 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,369,100.00 | 75,000.00 | 1,294,100.00 | 5.5 |
| Газрын төлбөр | 141,600.00 | 0.00 | 141,600.00 | 0.0 |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 10,000.00 | 0.00 | 10,000.00 | 0.0 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 300,000.00 | 293,950.00 | 6,050.00 | 98.0 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 336,800.00 | 336,750.00 | 50.00 | 100.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 336,800.00 | 336,750.00 | 50.00 | 100.0 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,849,700.00 | 6,849,617.11 | 82.89 | 100.0 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 6,849,700.00 | 6,849,617.11 | 82.89 | 100.0 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 6,849,700.00 | 6,849,617.11 | 82.89 | 100.0 |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 22.00 | 22.00 | - | 100.0 |
| Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 18.00 | 18.00 | - | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| Гэрээт ажилтан | 2.00 | 2.00 | 0.00 | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс эрхэм зорилгоо “Монгол улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэж тодорхойлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай Эрүүл мэндийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Баянхонгор Стандарт, хэмжил зүйн хэлтэс 2020 оны "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайланг дагуу Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 569,387.3 мянган төгрөг буюу 29.7 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 9,292.0 | - | (9,292.0) |
| Авлага | 145,319.7 | 389,536.8 | 244,217.0 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 133,760.1 | 112,498.4 | (21,261.7) |
| Үндсэн хөрөнгө | 1,960,888.4 | 2,203,392.5 | 242,504.1 |
| Хуримтлагдсан элэгдэл | (330,596.7) | (217,376.8) | 113,219.9 |
| **Нийт хөрөнгө** | 1,918,663.6 | 2,488,050.9 | 569,387.3 |
| Өр төлбөр | 2,112.9 | 194,863.5 | 192,750.6 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,916,550.6 | 2,293,187.4 | 376,636.8 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,918,663.6 | 2,488,050.9 | 569,387.3 |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлгүй болж өмнөх оноос 9,292.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн үлдэгдлийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Улсын төсвийн харилцах дансанд санхүүжилтээр 371,942.8 мянган төгрөг, сорьц баталгаажуулалтын төлбөрт 946,481.3 мянган төгрөг орж, 912,094.0 мянган төгрөг зарцуулж 406,690.1 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 60,108.6 мянган төгрөгийн нэмэлт орлого төвлөрч 59,498.6 мянган төгрөг зарцуулж, 610.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Ахмадын сангийн дансанд 9,292.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 2,500.0 мянган төгрөгийг зарцуулан оны эцэст 6,792.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Авлагын дансны үлдэгдэл 389,536.8 мянган төгрөг болж өмнөх оноос 244,217.0 мянган төгрөгөөр өссөн нь оны эхэнд ЭМ,НДШ-ийн авлага 5,398.7 мянган төгрөг байсныг барагдуулж 903.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон бол 139,921.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн авлага 388,633.3 мянган төгрөг болж нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 112,498.4 мянган төгрөг болж 21,261.7 мянган төгрөгөөр буурсан нь Эм боох материал 10,313,3 мянга, бусад хангамжийн материал 910.0 мянга, аж ахуйн материал 3,184.8 мянга, тусгай зориулалтын материал 2,477.3 мянга, барилгын засварын материал 3,184.9 мянга, сэлбэг хэрэгсэл 1,480.0 мянган төгрөгөөр буурсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Тайлан онд бараа материал төсвийн хөрөнгөөр 104,324.6 мянга, үнэ төлбөргүй 1,139.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, 126,725.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,203,392.5 мянган төгрөг болж 242,504.1 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө 100,426.0 мянган төгрөгөөр, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 193,038.2 мянга, ашиглалтын хугацаа дуусаж дахин үнэлж орлогод бүртгэсэн 154,824.8 мянган төгрөгөөр нэмэгдэж 15,094.5 акталж, дахин үнэлэгдсэн 191,290,4 мянган төгрөг дахин үнэлгээгээр хорогдсон 95,170.7 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хассан байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 194,863.5 мянган төгрөг болж өмнөх оноос 192,750.6 мянган төгрөгөөр өссөн нь оны эхэнд байсан түлш халаалтын 2,112.9 мянган төгрөгийн барагдуулсан бол нэмэлт санхүүжилтийн дансны эрх нээж өгөөгүйгээс байгууллага, хувь хүмүүст өгөх өглөг 173,346.1 мянга, албан томилолтын өглөг 20,808.4 мянга, шатахууны 752.6 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,293,187.4 мянган төгрөг болж 569,387.3 мянган төгрөгөөр өссөн өмнөх оны нэмэлт санхүүжилтийн авлага шийдэгдээгүйгээс 139,497.0 мянган төгрөгийн өмнөх үеийн үр дүнд хаасан, нь тайлант үеийн үр дүн 516,557.8 байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,231,697.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 253,585.2 мянган төгрөгөөр нэмж 978,112.5 мянган төгрөгөөр анх баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 4 удаагийн тодотгол хийж 936,942.8 мянган төгрөг болгон тодотгож гүйцэтгэлээр 912,09.4.0 мянган төгрөгийн буюу 97.3 хувийн гүйцэтгэл гаргаж ажилласан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 891,263.1 | 866,459.0 | 24,804.1 | 97.2 |
| 82314 | Мэдээлэл, сурталчилгааны зардал | 9,800.0 | 9,800.0 | 0.0 | 100.0 |
| 80219 | Харуул, хамгаалалтын зардал | 28,530.0 | 28,485.4 | | |
| 80224 | Зөвлөл, хороо, комиссын гишүүд | 500.0 | 500.0 | | |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 6,849.7 | 6,849.6 | | |
| | НИЙТ | 936,942.8 | 912,094.0 | 24,804.1 | 97.3 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус байгууллага нь Санхүү тооцоолох ХХК-ийн Acolous санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашигладаг ба тайлант онд программтай холбоотой зардал гараагүй байна.

Хоолны хөнгөлөлтөд 59,655.8 мянган төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 59,562.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Цалингийн зардлын төсвийг нийт 22 албан хаагчийн 611,625.4 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 611,377.1 мянган төгрөг зарцуулсан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитын менежер М.Алтантуяа, дарга тэргүүлэх аудитор Б.Мөнбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сонгосон суурь үзүүлэлт болох 2025 оны батлагдсан төсөв 936,942.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,369.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Батлагдсан төсвийг зориулалт ангиллын дагуу соортолж горим сорил гүйцэтгэхэд Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн асуудал гараагүй.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод 166 мэдээллийг бүрэн байршуулсан бөгөөд 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгээгүй

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар 14,100.0 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг залруулсан байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт санхүүжилтийн давсан орлого зарцуулж өр төлбөр үүсгэсэн 192,750.6 мянган төгрөгийн өр төлбөрийг анхаарах шаардлагатай

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 20,968.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2 албан шаардлага хүргүүлэв

Аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь материаллаг байдлын түвшингээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгөв.

### 5.1 Албан шаардлага

5.1.1. Бараа материалын дансанд сорил гүйцэтгэхэд эд хариуцагчийн тайлан санхүүгийн тайлангаас 11,168.0 мянган төгрөгийн зөрүүтэй буюу зарим дүнг давхардуулан илэрхийлсэн, эргэлтийн хөрөнгийн тооллогын тайланг гаргаж тооцоо бодоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13 дугаар зүйлийн 13.4-т заасан "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Эд хариуцагчийн тайланг үнэн зөв залруулж эхний хагас жилд багтаан биелэлтийг ирүүлэх, цаашид эд хариуцагчийг чадавхжуулж, тооллого хийж буй албан хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.1.2. "Алсын гэрэл" ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Мэдээ, сурвалжилга, нэвтрүүлэг, ярилцлага, шууд дамжуулалт хийх зорилготой "Хамтран ажиллах гэрээ"-г 14,000.0 мянган төгрөгөөр байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр 9,800.0 мянган төгрөг шилжүүлж, гэрээг дүгнээгүй, ажлыг хүлээн авсан акт үйлдээгүй, ажил бүрэн хийж дуусаагүй, гэрээний хугацааг тодорхой заагаагүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Цаашид хуулиар хориглосон арга хэмжээнд хөрөнгө зарцуулахыг таслан зогсоож, "Алсын гэрэл" ХХК-тай байгуулсан гэрээнд нэмж хөрөнгө зарцуулахгүй гэрээний хэрэгжилтийг тооцож ажлыг хүлээн авах.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын дансанд сорил гүйцэтгэхэд эд хариуцагчийн тайлан санхүүгийн тайлангаас 11,168.0 мянган төгрөгийн зөрүүтэй буюу зарим дүнг давхардуулан илэрхийлсэн, эргэлтийн хөрөнгийн тооллогын тайланг гаргаж тооцоо бодоогүй байна. | 1 | 11,168.0 | | | 1 | 11,168.0 | | |
| "Алсын гэрэл" ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Мэдээ, сурвалжилга, нэвтрүүлэг, ярилцлага, шууд дамжуулалт хийх зорилготой "Хамтран ажиллах гэрээ"-г 14,000.0 мянган төгрөгөөр байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр 9,800.0 мянган төгрөг шилжүүлж, гэрээг дүгнээгүй, ажлыг хүлээн авсан акт үйлдээгүй, ажил бүрэн хийж дуусаагүй, гэрээний хугацааг тодорхой заагаагүй байна. | 1 | 9,800.0 | | | 1 | 9,800.0 | | |
| **Нийт дүн** | **2** | **20,968.0** | | | **2** | **20,968.0** | | |

------------oOo------------